



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР  
МӨРДӨН ШАЛГАХ ХЭЛТЭС

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас/Факс: (976) 7011-0251,  
www.iaac.mn, E-mail: comcor@iaac.mn

201809-17 № 06/7505

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

「ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАРТ

Тус хэлтсээс мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа эрүүгийн 170603144 дугаартай хэрэгт прокурорын мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай 70 тоот зөвшөөрөлд дурдсан “Соёлт өргөө констракшн” ХХК-д газар эзэмшүүлэх дуудлага, худалдаа зохион байгуулахтай холбоотой баримт бичгийг гаргаж ирүүлнэ үү.

Жич: Прокурорын зөвшөөрлийг хавсралтаар хүргүүлэв.

АЛБАНЫ ДАРГА,  
АХЛАХ КОМИССАР

Ц.ЭНХБАЯР



## ПРОКУРОРЫН ЗӨВШӨӨРӨЛ

2018 оны 09 дүгээр  
сарын 14-ний өдөр

Дугаар ...70

Улаанбаатар  
хот

### Мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай

Баянзүрх дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор Г.Эрдэнэ би, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч, ахлах комиссар Д.Золжаргалын мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй эрүүгийн 170603144 дугаартай хэрэгт "мэдээлэл баримт, бичиг гаргуулан авах" мөрдөн шалгах ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн саналын дагуу хэргийг хянаад ОЛСОН нь:

М.Мөнхсоёл, Б.Ариунболд нар нь 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдөр иргэн Ч.Түмэнбаяраас 2 сарын хугацаанд Баянзүрх дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 360м<sup>2</sup> талбай бүхий 2 давхар, гражийн зориулалттай объектыг чинь барьцаанаас чөлөөлөөд буцаагаад аваад өгнө гэж хуурч уг үл хөдлөх хөрөнгийг нь иргэн Д.Пүрэвдаваад худалдах худалдан авах гэрээгээр шилжүүлүүлэн сарын 4 хувийн хүүтэй, 100 сая төгрөгийг зээлдүүлэн 92 сая төгрөгийг нь авч залилсан гэх хэрэгт Хэнтий аймгийн Хэрлэн сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэр, Дулааны энгэр гэх газарт "Соёлт Өргөө констракшн" ХХК-д эзэмшүүлэх дуудлага худалдааг зохион байгуулахтай холбоотой болон газар эзэмшүүлэхтэй холбоотой баримт бичгийг Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газраас, "Соёл Өргөө констракшн" ХХК-д газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээ, газрын төлбөр төлсөн баримтуудыг Хэнтий аймгийн Газрын албанаас гаргуулан авах зөвшөөрлийг олгох мөрдөн шалгах ажиллагааг явуулах үндэслэлтэй байна.

Иймд Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, мөн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дах хэсэгт заасныг тус тус удирдлага болгон прокурорын зөвшөөрөл олгов.

ХЯНАЛТЫН ПРОКУРОР,  
ХУУЛЬ ЦААЗЫН ДЭД ЗӨВЛӨХ

Г.ЭРДЭНЭ

